



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/581

Эрдэнэт



Хөрөнгө гаргах тухай




Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.14.1, Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 3.7.5, “Эмч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд зохион байгуулах “Чиглүүлэгч багш”-ийн сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 8-11-ний өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, зардлыг хавсралтаар баталсугай.


2.Шаардагдах 2000000 /Хоёр сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2017 оны “Хуваарилалт хийх тухай” А/306 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Аймгийн хамтын ажиллагаатай улс орнуудтай эрүүл мэндийн байгууллагын удирдлага зохион байгуулалт, эрүүл мэндийн даатгал, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, халдвар хамгааллын чиглэлээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулах” зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/, Бүсийн оношлогоо эмчилгээний төв /н.Батсүх/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ



### ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материал	Тоо ширхэг	Давтамж	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Цайны зардал	39	6	2000	468000
3	Өдрийн хоол	39	3	8500	994500
4	Бичиг хэрэгсэл	24	1	2500	60000
5	Бичгийн цаас, принтер хор	2	1	60000	60000
6	Бэлэг дурсгал	11	1	25000	275000
7	Бусад				142500
<b>Нийт дүн</b>					<b>2000000</b>